

ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРАЛ,  
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН 2021 ОНЫ 08 ДУГААР САРЫН МЭДЭЭ

НЭГ. УДИРДЛАГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТАЛААР:

Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн хуралдаан 1 удаа хуралдаж, аймгийн баяр зохион байгуулахыг зөвшөөрч, хороо байгуулах тухай асуудлыг хэлэлцэн шийдвэрлэснээр Тулгар төрийн 2230, Их Монгол Улсын 815, Ардын хувьсгалын 100 жил, Говь-Алтай аймаг байгуулагдсаны 98 жилийн ойн баярыг цар тахлын нөхцөл байдлаас шалтгаалан үзэгчгүйгээр зохион байгуулж, ТВ9 телевизээр шууд дамжуулан үзэгч түмэндээ хүргэлээ. Энэ удаагийн “Цахим баяр” нь улсын цолтой бөхчүүдийг барилдуулахгүй байх шийдвэр гаргаж, аймгийн харьяат аймаг, сумын цолтой 128 бөхийг нээлтийн үеэр чин шударга барилдах тангараг өргүүлэн барилдуулснаараа онцлогтой байлаа. Энэ жилийн баярт хүчит 128 бөх уран мэхээ уралдуулж, шагайн харвааны 5 багийн 40 харваач, сур харвааны 86 харваач цэц мэргээ сорьж, 310 хурдан буян шандас хурдаа шалгалаа.

Монгол Алтайн нурууны 13 мөнх цаст оргилын нэг Сутай хайрхан уулын тэнгэрийг тайх төрийн ёслолын арга хэмжээг 8-р сарын 6, 7-ны өдрүүдэд зохион байгуулж, тахилгад Монгол Улсын ерөнхийлөгч Ухнаагийн Хүрэлсүх хүрэлцэн ирж, оролцлоо.

ХААИС-тай хамтран 8 дугаар сарын 28-ны өдөр тус аймгийн Тайшир сум дахь Агро инноваци, сургалт судалгааны төвийн нээлт, "Ургацын баяр 2021" арга хэмжээг зохион байгуулж, уг арга хэмжээнд ХААИС-ийн эрдэмтэн докторууд, Монголын тариаланчид гурил үйлдвэрлэгчдийн холбоо, ХХААХҮЯамны төлөөлөл, тус аймгийн удирдлагууд, албан байгууллага, аж ахуй нэгжийн дарга, эрхлэгч болон холбогдох албан хаагчид, тариаланчид, нийт 300 гаруй хүн оролцож, "Газар тариалан жимс жимсгэнэ төсөл" - ийн хүрээнд байгуулсан Агро Инноваци сургалт судалгааны төвийн үйл ажиллагаатай танилцаж, төслийн хүрээнд хийгдсэн ажил, цаашдын зорилго төлөвлөгөөтэй танилцаж шинэ ургацын бүтээгдэхүүний дээжээс хүртлээ. Мөн аймгийн газар тариалангийн бүс нутаг болох Цогт, Халиун, Дэлгэр, Жаргалан, Тайшир, Шарга, Дарви, Бигэр, Чандмань сумдын тариаланчид оролцож шинэ ургацын дээж, брэнд бүтээгдэхүүнүүдээрээ үзэсгэлэн гаргаж, туршлага солилцон, ХААИС-ийн эрдэмтдээс зөвлөгөө авч, сургалтад хамрагдаж, мэдлэг, чадвараа дээшлүүллээ. Нээлтийн үеэр Олон улсын таримал судлалын хүрээлэн, Таримал Ой Судлал, Ландшафт, Архитектурын тэнхимийн багш, доктор Т. Насанжаргал, аймгийн Засаг дарга О.Амгаланбаатар нар аймгийн газар тариалан, жимс жимсгэний тариалалтыг өргөжүүлэн хөгжүүлэх санамж бичигт гарын үсэг зурж, хамтын ажиллагаагаа баталгаажууллаа.

Хичээл сургуулийн үйл ажиллагаа эхлэх гэж буйтай холбогдуулан НҮБ-ын Хүүхдийн сангийн Ус хангамж, ариун цэвэр, эрүүл ахуйн хөтөлбөрөөс сургууль, цэцэрлэгүүдэд нэн шаардлагатай халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх 6 нэр төрлийн, 40.5 сая төгрөгийн ариутгал халдваргүйжүүлэлтийн бодис, тоног төхөөрөмжийг хүлээлгэн өглөө.

Тус аймгийн Тайшир сумын ймгийн аварга малчин Н. Алтанцэцэгийн "Улсын аварга саальчин" цол, шагналыг гардуулан өглөө.

Япон улсын Хүүхдийг ивээх сангаас "Шороон шуурганд өртсөн хүүхэд, малчин өрхийн амьжиргааг дэмжих" төслийн хүрээнд 19 өрхөд гэр, 115 өрхөд эрүүл ахуйн багц, 70 өрхөд мөнгөн тусламж үзүүллээ.

"Монгол гэрийн халаалт, дулаалга агаар сэлгэлтийн багц буюу Чип төсөл"-ийн хэрэгжүүлэгч Пипл ин нийд олон улсын төрийн бус байгууллагын төлөөлөлтэй 2021 оны 08 дугаар сарын 19-ны өдөр уулзаж төслийн үр дүн болон цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар зөвлөлдлөө.

**Гамшгаас хамгаалах чиглэлээр:** Аймгийн Онцгой комиссын хурлын шийдвэрийн дагуу гамшгаас урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах, тэмцэх, коронави халдвараас урьдчилан сэргийлэх ажилд зориулж аймгийн Гамшгийн сангаас нийт 45.6 сая төгрөгийг зарцууллаа.

Есөнбулаг сум дахь Эрэн хайх, аврах салбар байрлах Онцгой байдлын хуучин барилгын засварын ажилд шаардагдах 19.7 сая төгрөг, Цогт сум дахь Эрэн хайх, аврах бүлэг байрлах Эрүүл мэндийн төвийн хуучин барилгын засварын ажилд шаардагдах 19.9 сая төгрөгийг аймгийн Гамшгийн сангаас тус тус шийдвэрлэлээ.

Тайлант хугацаанд гал түймрийн улмаас иргэдэд 2.5 сая төгрөгийн хохирол учирч, 3.0 сая төгрөгийн өмч хөрөнгийг гал түймрийн аюулаас авран хамгааллаа.

Засгийн газрын 2021 оны 34 дүгээр хуралдааны тэмдэглэлээр өгсөн үүрэг даалгаврын хэрэгжилтийг хангуулах ажлын төлөвлөгөөг гаргаж, 2021 оны 08 дугаар сарын 20-ний өдрийн 3/868 дугаар албан бичгээр, бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн эхний хагас жилийн биелэлттэй холбогдуулан гарсан зөвлөмжийг хэлтэс, агентлагуудад тус тус хүргүүллээ.

Тус аймаг дахь Төрийн аудитын газарт аймгийн Засаг даргын Тамгын газрын 2020 оны жилийн эцсийн болон 2 дугаар улирлын санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын шийдвэрийн хэрэгжилтийг хүргүүллээ.

**Өргөдөл гомдлын шийдвэрлэлт:** Тайлант хугацаанд нийт 16 өргөдөл бичгээр ирснээс 7 өргөдлийг шийдвэрлэж, 9 өргөдөл хяналтын шатандаа, хугацаандаа судлагдаж байна. Хугацаа хэтэрсэн өргөдөл гомдол байхгүй.

Шийдвэрлэлт 43.75 хувь, шийдвэрлэлтийн дундаж хугацаа 3 хоног байна.

"Иргэдээ сонсох нээлттэй утас 7048-1111" дугаарын утсанд 08 дугаар сарын байдлаар нийт 46 дуудлага хүлээн авснаас, хувийн мэдээллээ бүрэн өгсөн 39 гомдол, санал, хүсэлтийг E-office программд бүртгэн, холбогдох байгууллага, албан тушаалтанд шилжүүлэн, шийдвэрлэлтэд хяналт тавин ажиллаж байна. Шийдвэрлэж хариу өгсөн 19, хугацаандаа судлагдаж байгаа 20, хугацаа хэтэрсэн өргөдөл байхгүй байна. Шийдвэрлэлт 48.7 хувьтай байна.

**Цахим үйлчилгээний талаар:** "E-Mongolia" Төрийн үйлчилгээний нэгдсэн цахим операторын системээр нийт 54 нэр төрлийн лавлагаа, мэдээллийг иргэдэд нэг шатлалаар олгож байгаа бөгөөд тайлант хугацаанд төрийн цахим мэдээллийн

үйлчилгээг 20 иргэнд төлбөртэй, 65 иргэнд төлбөргүй, нийт 85 лавлагаа мэдээлэл гаргаж үйлчиллээ.

Нийт [WWW.OPERATOR.E-MONGOLIA.MN](http://WWW.OPERATOR.E-MONGOLIA.MN) цахим мэдээллийн системээр үзүүлсэн лавлагаа, тодорхойлолтын үйлчилгээний хураамж 17000 төгрөгийг холбогдох дансанд төвлөрүүлээ.

Төрийн цахим үйлчилгээний E-mongolia сайтыг иргэдэд танилцуулах, шаардлагатай лавлагаа тодорхойлолтуудыг нэг шатлалаар богино хугацаанд авах, цахим порталын хэрэглээг нэмэгдүүлэх үүднээс үйлчилгээний нэгдсэн төвөөс иргэдэд мэдээ мэдээлэл, заавар зөвлөмжийг байнга өгч байна. Иргэдийн хүсэлтээр хувийн мэдээллээр нь бүртгэл үүсгэж, хэрэгцээтэй лавлагаа тодорхойлолтуудыг 154 иргэнд үнэ төлбөргүй гарган үйлчиллээ.

Сумдын цахим мэдээлэл лавлагааны дүнг нэгтгэж, тайлан мэдээг Харилцаа холбооны зохицуулах хороонд сар бүрийн 05-ны дотор хүргүүлэн ажиллаж байна.

Үйлчлүүлэгчдийн хэвлэх, олшруулах үйлчилгээг 216 иргэнд үзүүллээ.

Аймгийн нийгэм, эдийн засгийн 2021 оны 7 дугаар сарын танилцуулга, инфографикийг бэлтгэн хэлтсийн вэб сайт болон фэйж хуудсаар дамжуулан хэрэглэгчдэд тархаалаа.

Авлига, албан тушаалтны гэмт хэргийн статистик үзүүлэлтүүдээр инфографик бэлтгэн гаргаж, Статистикийн хэлтсийн вэб сайтад байршуулан тархаалаа.

#### ХОЁР. ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН БОДЛОГЫН ХҮРЭЭНД:

Архивын баримтаас лавлагаа захиалгын дагуу 113 иргэнд мал тооллого, цалингийн лавлагаа болон тушаалын хуулбар нийт 580 хуудас баримт хувилж олшруулсны 1156.0 мянган төгрөгийг төрийн сангийн дансанд төвлөрүүлээ

Архивын 2 сумын мал тооллогын бүртгэлийн 2 хадгаламжийн нэгжийн 1296 хуудас баримтын 983 хүний нэрийг шивж цахим хэлбэрт шилжүүллээ.

Цахимжуулалт хариуцсан ажилтнууд цахим хэлбэрт шилжүүлсэн баримтын сарын мэдээ гаргаж, Архивын ерөнхий газарт мэйлээр илгээсэн болно.

Хууль зүй дотоод хэргийн сайдын 2021 оны А/173 дугаар тушаалаар баталсан удирдамжийн дагуу Төрийн архивын улсын үзлэгт бэлтгэх ажлын төлөвлөгөө боловсруулан, хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

Онлайн лавлагааны цахим системээр 12 иргэнд хүн амын тооллого, хөдөлмөр эрхлэлтийн талаарх лавлагааг олголоо.

Авлигатай тэмцэх газраас албан бичиг ирсний дагуу Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийг зөрсөн Бугат, Төгрөг сумдын Засаг даргад аймгийн Засаг даргын 2021 оны 08 дугаар сарын 09-ний өдрийн Б/48, Б/49 дүгээр захирамжаар сахилгын шийтгэл ногдуулж, Авлигатай тэмцэх газрын Хяналт шалгалт дүн шинжилгээний хэлтэс болон сахилгын шийтгэл хүлээсэн албан тушаалтанд тус тус хүргүүллээ.

Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн дагуу Нийтийн албанд

томилогдохоор нэр дэвшсэн 2 хүний хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийг meduuleg.iaас.mn цахим системд бүртгэж, баталгаажуулан, Авлигатай тэмцэх газрын хяналт шалгалт дүн шинжилгээний хэлтэст хянуулахаар хүргүүллээ.

Тус аймгийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөл, аймгийн Прокурорын газраас зохион байгуулж буй “Судалъя, Мэдье, Сэргийлье” нөлөөллийн аяны хүрээнд 2021 оны 08 дугаар сарын 31-ний өдөр Авлигатай тэмцэх газраас аймгийн зохион байгуулсан цахим сургалтад 20 албан хаагч хамрагдаж, мэдлэг чадвараа дээшлүүллээ.

"Ирээдүйгээ хамгаалъя", "Орон нутгийн зам-Хөдөлгөөний соёл 2021" арга хэмжээний хүрээнд аймгийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөл болон аймагт үйл ажиллагаа явуулж буй даатгалын кампануудтай хамтран Баян-Өлгий, Ховд аймгийн чиглэлийн улсын чанартай замд "Би амлалтаа биелүүлдэг жолооч" нөлөөллийн арга хэмжээг зохион байгуулж, зам тээврийн ослоос урьдчилан сэргийлэх яриа таниулга хийж, илэрсэн зөрчлийг газар дээр арилгуулан, зөвлөмж сэрэмжлүүлгийг өгч, зөрчил гаргасан жолооч нараас гаргасан зөрчлийг давтан гаргахгүй байх талаар амлалт авч байна.

Засгийн газрын хуралдааны 2021 оны 06 дугаар сарын 08-ны өдрийн 34 дүгээр тэмдэглэлээр өгсөн үүрэг даавлгаврын хэрэгжилтийг хангуулах ажлын төлөвлөгөөг батлан, хэрэгжилтийг тооцон ажиллаж байна.

## ГУРАВ. ЭДИЙН ЗАСАГ, ТӨСӨВ, САНХҮҮ, ХУДАЛДАН АВАХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЧИГЛЭЛЭЭР

Орон нутгийн болон тусгай зориулалтын шилжүүлгийн байгууллагуудын 08 дугаар сарын санхүүжилтыг хуваарийн дагуу сумдад 5689.5 сая төгрөг, шууд харилцагч байгууллагуудад 7456.7 сая төгрөг, ЕБС-1864.5 сая төгрөг, СӨБ-7589.5 сая төгрөг, ГХБХБГ-245.6 сая төгрөг, ХГБХГ-265.3 сая төгрөгийг тус тус олгон, төсвийг зориулалтын дагуу зарцуулахад хяналт тавин ажиллаж байна.

**Худалдан авах ажиллагаа:** Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2021 оны худалдан авах ажиллагааны ерөнхий төлөвлөгөөнд 11.5 тэрбум төгрөгийн 87 төсөл арга хэмжээг төлөвлөж 64 арга хэмжээний гүйцэтгэгчийг сонгон шалгаруулж 73.5 хувийн гүйцэтгэлтэй байна.

**Хөрөнгө оруулалтын талаар:** Аймгийн хэмжээнд 2021 онд улсын төсвийн хөрөнгөөр шилжих болон шинээр 43, ОНХСангийн хөрөнгөөр 27, орон нутгийн төсвийн хөрөнгөөр 4, орон нутгийн замын сангийн хөрөнгөөр 6, нийт 39.4 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй 80 төсөл арга хэмжээг хэрэгжүүлж байна.

Эхний 8 сарын гүйцэтгэлээр улсын төсвөөс 2.0 тэрбум, орон нутгийн хөгжлийн сангаас 1.4 тэрбум, орон нутгийн замын сангаас 120.0 сая, орон нутгийн төсвөөс 224.9 сая төгрөгийн санхүүжилт тус тус олголоо.

**Өмчийн асуудлаар:** Нэгдсэн үндэстний байгууллагын Хүүхдийн сангийн хөрөнгөөр хийгдсэн Халиун, Бигэр сумын худгийг ухаалаг системд шилжүүлэх, Тонхил сумын сургуулийн дотуур байр, Бугат сумын цэцэрлэгийн ариун цэврийн

байгууламжийг ашиглалтад оруулах улсын комисст ажиллан өмчид бүртгүүлэх ажлыг зохион байгууллаа.

## ДӨРӨВ. ХӨДӨӨ АЖ АХУЙН ЧИГЛЭЛЭЭР

Монгол Улсын Засгийн газрын “Хөдөө аж ахуйн салбарын 2021-2022 оны өвөлжилт, хаваржилтын бэлтгэл хангах зарим арга хэмжээний тухай” 2021 оны 221 дүгээр тогтоол, Монгол Улсын Шадар сайд болон ХХААХҮЯ-ны сайдын албан даалгаврыг эрчимжүүлэх зорилгоор аймгийн Засаг даргын 2021 оны А/379 дугаар захирамжаар томилогдсон Хөдөө аж ахуйн салбарын өвөлжилтийн бэлтгэл хангах ажлын хэсгийн ээлжит хурал хуралдаж, ХХААГ-ын даргын мэдээллийг сонсож, холбогдох байгууллага, сумдын Засаг дарга нарт үүрэг чиглэл өглөө.

Ажлын хэсгийн бүрэлдэхүүн Цогт сумын Баянтоорой тосгон, Бигэр, Чандмань, Эрдэнэ, Цээл, Халиун, Төгрөг, Шарга, Дарив, Жаргалан сумдад ажиллан, “Газар тариалан жимс жимсгэнэ” төслийн хэрэгжилтэд хяналт тавьж, ургац хураалтын бэлтгэл ажилтай танилцаж, зөвлөгөө өглөө.

Аймгийн хэмжээнд хураан авах ургацын урьдчилсан балансаар 1382 га-аас 3676 тн ургац авна гэсэн тооцоо байна. Үүнд: Үр тариа 304.6 га-аас 427 тн, төмс 62.1 га-аас 466 тн, хүнсний ногоо 69.4 га-аас 458 тн, жимс, жимсгэнэ 141 га-аас 70.5 тн, ногоон тэжээл 805 га-аас 2255 тн ургац тус тус хураан авах төлөвтэй байна.

**Мал эмнэлгийн чиглэлээр:** Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 43 дугаар тогтоол, аймгийн Засаг даргын 2020 оны А/148 дугаар захирамж, Мал эмнэлгийн ерөнхий газрын даргын 2021 оны А/174 дүгээр тушаалын хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд малын шилжилт хөдөлгөөн, отор нүүдэл, мал эрүүлжүүлэх ажлын гүйцэтгэлд хяналт тавьж ажиллах талаар сумдад хүргүүлж, холбогдох заавар зөвлөгөө өгч ажиллаж байна. Аймгийн Засаг даргын “Бруцеллёзын вакцинжуулалтыг зохион байгуулах” тухай 2021 оны А/346 дугаар захирамжийн дагуу аймгийн хэмжээнд 10,0 мянган тугал, 200,0 мянган хурга, 300,0 мянган ишиг, нийт 510,0 мянган төлийг вакцинжуулалтад хамруулахаар ШТАМ-19 вакцин 10000 тун, РЕВ-1 вакцин 500000 тунг сумдад хүргүүлснээр 08 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн вакцинжуулалтын ажил эхэлсэн бөгөөд 3765 тугал, 71016 хурга, 97980 ишиг, нийт 172761 төл мал хамрагдаж, 33.9 хувийн гүйцэтгэлтэй байна.

**Жижиг дунд үйлдвэрлэлийн чиглэлээр:** Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Жижиг, дунд үйлдвэрийн газрын ажлын хэсэгтэй хамтран 8 дугаар сарын 1,2-ны өдрүүдэд Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангаас зээл авсан аж ахуйн нэгжийн үйл ажиллагаатай танилцаж, зээлийн үлдэгдлийг баталгаажуулж тулгалт хийлээ.

Монгол банкны зээлийн мэдээллийн санд Сум хөгжүүлэх сангийн зээлдэгчдийн мэдээлэл нэгтгэгдсэнтэй холбогдуулан зээлээ бүрэн төлсөн зээлдэгчийн мэдээллийг хэвийн ангилалд оруулах ажлыг тухай бүр нь зохион байгуулан ажиллаж байна.

**Газрын харилцаа, барилга хот байгуулалтын чиглэлээр:**

**Газрын харилцаа:** Газар зохион байгуулалт, геодизи зураг зүйн газрын даргын 2015 оны А/105 дугаар тушаалаар батлагдсан “Бэлчээрийн газрыг фото

мониторингийн аргаар үнэлэх журам, заавар"-ын хүрээнд 8 дугаар сард аймгийн хэмжээнд нийт 310 цэгт хээрийн судалгааг хийж, боловсруулалтын ажил хийгдэж байна.

**Барилга, хот байгуулалтын чиглэлээр:** Аймагт хэрэгжиж буй хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээний явцад хяналт шалгалт хийх ажлын хэсгийг томилон ажиллуулж, ажлын мэдээлэлтэй 2 удаа танилцан холбогдох байгууллагуудад үүрэг чиглэл өгч хэрэгжилтэд хяналт тавин ажиллаж байна.

“Сумдын шинэчлэл хөдөөгийн хөгжил” төслийн хүрээнд Алтай, Баян-Уул, Бугат, Дарив, Дэлгэр, Жаргалан, Тайшир, Тонхил, Төгрөг, Цогт, Цээл, Халиун, Шарга, Хөхморьт, Чандмань, Эрдэнэ сумдад баригдах 120 айлын орон сууцны барилга угсралтын ажлын зураг төслийг орон нутгийн хөгжлийн сангийн 98.2 сая төгрөгийн санхүүжилтээр, Алтай хотын 1.5 км цэвэр усны шугам шинэчлэн солих ажлыг 28.5 сая төгрөгийн санхүүжилтээр гүйцэтгүүлэн, магадлалаар баталгаажуулж хүлээн авлаа.

Мөн Дэлгэр, Эрдэнэ, Чандмань, Бигэр, Цогт, Цээл, Төгрөг, Шарга, Есөнбулаг сумдад улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжиж буй барилга байгууламж, их засварын ажлын явцтай танилцан мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч ажиллалаа.

**Барилгын материал үйлдвэрлэл, лабораторийн чиглэлээр:** Тоосго, цемент, бетон сорьц, явган замын хавтангаас дээж авч лабораторит шинжилгээнд хамруулж байна. Үүнд:

- Хувийн хөрөнгө оруулалтаар хэрэгжиж буй “Чавгын шанд” ХХК-ийн тоосгоны үйлдвэрийн тоосго, “Аксу-Алтай” ХХК-ийн бетон зуурмагийн үйлдвэрийн зуурмаг, иргэн Ё.Хатанбаатарын Үйлчилгээний барилгын гадна талбай, Солонго хорооллын 50 айлын орон сууцны 2 барилгын бетон
- Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжиж буй Алтай хотын явган замын тохижилт, 1, 2-р сургуулийн спорт заалны дүүргэлтийн блок, бетон, Шарга сумын Ээвийн голын 65 у/м төмөр бетон гүүр, Ахмадын сувиллын барилгын бетон, Цэнгэлдэх хүрээлэн зэрэг барилгуудад сорьц болон цементийн дээжид шинжилгээ хийж, үр дүнг холбогдох аж ахуй нэгжүүдэд тус тус хүргүүллээ.

**Ус хангамж:** “Ундарга-Алтай” ААТҮГ нь ундны усны 4 гүний худаг, 1 нөөцийн худагтайгаар Алтай хотын ард иргэдийн унд ахуйн хэрэгцээг хангадаг бөгөөд нийт 41022 м3 ус олзворлон түгээж, 36023 м3 усыг даралтат усан санруу шахаж, хэрэглэгчдэд түгээлээ.

Тайшир сумын гэгээн нуураас Алтай хотын иргэдэд зөөврийн цэвэр усны түгээлтийг “Гэгээн нуур цэвэр ус” ААТҮГ хариуцан ажиллаж байгаа бөгөөд энэ сард 18.9 л торхтой ус 7833 ширхэг үйлдвэрлэж 7560 ширхгийг, 0.5 л савалгаатай усыг 10600 ширхэг үйлдвэрлэж, 10050 ширхгийг, нийт 17610 ширхэг савалгаатай ус иргэдэд борлууллаа.

**Ариутгах татуурга:** Алтай хотын төв цэвэрлэх байгууламжид 35500 м3 бохир усыг хүлээн авч цэвэршүүлсэн бөгөөд усанд уусаагүй хольц буюу овор хэмжээ ихтэй 3,6 м3 хог хаягдлыг татан зайлуулж хогийн талбайд хаясан.

**Гэмтэл засвар:** “Тайшир-Алтай” усан хангамжийн төслийн хүрээнд Алтай хотод байрлах шинээр баригдсан 2000 багтаамжтай нөөц усны байгууламжаас аймгийн одоо хэрэглэж байгаа 1000 багтаамжтай усан сан болон аймгийн усан хангамжийн нэгдсэн худагруу холбох шугам хоолойн ажлыг гүйцэтгэгч “Сайрам булган” ХХК болон “Ундарга-Алтай” ААТҮГ-ын инженер техникийн ажилчид хамтран гүйцэтгэлээ.

**Борлуулалт:** Тайлант хугацаанд “Ундарга-Алтай” ААТҮГ-т төсвийн байгууллагаас 20.0 сая, орон сууцны айл өрхөөс 0.5 сая төгрөгийн орлого тус тус төвлөрлөө

#### **Дэд бүтцийн салбарт**

**Эрчим хүчний чиглэлээр:** Аймгийн Засаг даргын 2021 оны А/356 дугаар захирамжаар Төв суурин газрын өвөлжилтийн бэлтгэлийг хангах ажлын хэсэг томилогдон ажиллаж байгаа бөгөөд халаалт, усан хангамжийн ашиглалт хариуцсан байгууллагууд болон нэгдсэн халаалтын системтэй сумдын өвөлжилтийн бэлтгэл ажлын талаар хангагч байгууллагын удирдлага, ИТА, Есөнбулаг сумын ЗДТГ, аймгийн Эрчим хүчний зохицуулах орон тооны гишүүний мэдээллийг сонсож, холбогдох үүрэг чиглэл өгч, 9 дүгээр сарын 06-ны өдөр үйл ажиллагаатай нь танилцахаар шийдвэрлэлээ.

**Мэдээ тайлан:** Хүнсний нөөцийн мэдээг 7 хоногийн 1 болон 4 дэх өдөр сумдаас авч нэгтгэн ХХААХҮ-ийн яаманд, намрын ургац хураалтын техникийн бэлэн байдлын судалгааг авч нэгтгэн ХХААХҮЯамны Газар тариалангийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газарт тус тус хүргүүлээ.

### **ЗУРГАА. НИЙГМИЙН САЛБАР:**

**Эрүүл мэндийн чиглэлээр:** Гэмтэл согог судлалын үндэсний төв, Дэлхийн эрүүл мэндийн байгууллагын санхүүжилтээр “Цар тахлын нөхцөлд осол гэмтлийн яаралтай болон эмнэлгийн тусламж үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулах нь” сэдэвт сургалтад хамрагдах эмч, эмнэлгийн мэргэжилтэн, зорилтот бүлгийн иргэдийн нийт 160 хүний мэдээллийг Гэмтэл согог судлалын үндэсний төвд хүргүүлээ.

Захиалсан эм Ремдесивер 100мг-50 фл, Арбидол 100мг-1584 ширхэг эмийг татан авалтыг хийж нөөцөллөө.

Эрүүл мэндийн хөгжлийн төвөөс зохион байгуулсан сургалтад 6 сумын 13 эмч эмнэлгийн мэргэжилтэн, Эрүүл мэндийн газрын 2 мэргэжилтэн хамрагдлаа.

Коронавируст (КОВИД-19)-ын халдвар авсан 26 эмч, эмнэлгийн мэргэжилтний мэдээллийг авч нэгтгэн [ipc@nncd.gov.mn](mailto:ipc@nncd.gov.mn) хаягаар хүргүүлээ.

Тайлант хугацаанд коронавируст (КОВИД-19) халдвар батлагдсан 165 иргэнийг эмнэлэгт хэвтүүлэн эмчилж байна.

Ковид-19 халдвараас урьдчилан сэргийлэх дархлаажуулалтад аймгийн хэмжээнд огт хамрагдаагүй байгаа 2686 хүний нэгдсэн судалгааг гарган, 236 хүнээс вакцинд хамрагдаагүй байгаа шалтгааныг тодорхойлон, вакцинд хамрагдсанаар халдварт өвчнөөс сэргийлж болох талаарх мэдээлэл, зөвлөгөө өглөө. Ковид-19

дархалаажуулалтад огт хамрагдаагүй иргэдээс 26 иргэн вакцины 1-р тунд хамрагдаад байна.

Эрүүл мэндийн газрын ажлын хэсгийн бүрэлдэхүүн Цээл сумын "Алтайн Хүдэр" ХХК-ийн ажилчдад сүрьеэгийн үзлэг хийж, үзлэгт 600 иргэнийг хамруулан, 75 сорьц авснаас сэжиг бүхий 3, рентген зурганд илэрхий 1 хүний тохиолдол илэрч батлгаажуулалт хийж байна.

ДЭМБ-ын дэмжлэгтэйгээр Гэмтэл Согог Судлалын Үндэсний төв, тус аймгийн Эрүүл мэндийн газартай хамтран "Цар тахлын нөхцөлд осол гэмтлийн яаралтай болон эмнэлгийн тусламж үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулах" сургалтыг 2021 оны 8 дугаар сарын 17, 18-ны өдрүүдэд зохион байгуулж, нийт 160 гаруй хүн оролцож осол гэмтлийн үед яаралтай тусламжийг үзүүлэх мэдлэг, чадварыг эзэмшүүллээ. Сургалтын үеэр 19 сум, тосгон, Нэгдсэн эмнэлэгт нуруу, хүзүүний чиг, анхны тусламжийн цүнх зэргийн гардуулан өглөө.

Аймгийн хэмжээнд вакцины бүрэн тунд хамрагдсан 38083, вакцинд огт хамрагдаагүй 2660, зөвхөн 1-р тунд хамрагдсан 2945 хүн байгаа ба ковидын вакцины нөөц 9466 хүн.тун байна.

Төрийн сангийн санхүүжилтээр төгсөлтийн дараах сургалтад хамрагдах 7 эмнэлгийн мэргэжилтний бүртгэлийг, төгсөлтийн дараах сургалтад хамрагдаж багц цагаа биелүүлсэн 3 эмч мэргэжилтний материалыг хянаж Эрүүл мэндийн хөгжлийн төвд тус тус хүргүүллээ.

Эх, хүүхдийн эндэгдлийн талаар хэлэлцсэн Эрүүл мэндийн яамны Удирдлагын зөвлөлийн 2021 оны 23 дугаар хурлаас гарсан шийдвэрийн дагуу эхийн чиглэлээр 9, хүүхдийн чиглэлээр 6, нийт 15 үйл ажиллагаа төлөвлөж, харъяа байгууллагуудад хүргүүлэн, хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

Коронавирусын халдварын тархалт эрчимтэй нэмэгдэж 8 дугаар сард 1013 тохиолдол эерэг гарч, хавтигч 1236 хүн байна. Делта коронависын 30 ширхэг сорьцыг ХӨСҮТ рүү хүргүүлсний 7 сорьцод эерэг тохиолдол илэрсэн байна.

**Боловсролы чиглэлээр:** НҮБ-ын хүүхдийн сангаас 3.2 сая төгрөгийн халдвар хамгааллын хэрэгсэл, ариутгалын бодисоор тусламж үзүүлж ЭЕШ-ын хугацаанд дэглэмийг баримталж, эрсдэлийг бууруулан ажиллалаа.

Сургуулийн гаднах орчинд нэвтрэх хэсэг тус бүрд зурвас үүсгэх, халуун хэмжиж, гар ариутгах, металл ирүүлэгчээр шалгах цэг, бичиг баримт шалгах цэгүүдийг 2 метрээс багагүй байхаар бэлдэж, ариутгал цэвэрлэгээ хийсэн ба шалгалтын төвийн анги танхим, коридор, ариун цэврийн өрөө зэргийг нэг бүрчлэн ариутгалаа. Мөн шалгалтад орох гарах хаалгыг тусдаа байхаар тохируулж, шалгалтыг зохион байгуулсан болно.

Элсэлтийн ерөнхий шалгалтад 840 хүүхэд бүртгүүлж, 10 шалгалтад давхардсан тоогоор 2739 шалгуулагч хамрагдахаас 2500 шалгуулагч хамрагдаж, 91.3 хувь нь хамрагдлаа. Элсэлтийн ерөнхий шалгалтыг журам, хуваарь, удирдамжийн дагуу зохион байгуулсан. Шалгалтын явцад ямар нэгэн зөрчил гараагүй болно.

Шалгалтын нэр	Бүртгүүлсэн	Шалгалтад орсон	Ирээгүй	Ирц /хувь/	Ажилласан хянагч
---------------	-------------	-----------------	---------	------------	------------------



					багшийн тоо
Монгол улсын түүх	17	10	7	58.8	2
Англи хэл	455	428	27	94.1	31
Хими	200	183	17	91.5	14
Газар зүй	24	16	8	66.7	3
Нийгэм	540	504	36	93.3	37
Биологи	206	190	16	92.2	14
Математик	548	495	53	90.3	37
Физик	228	204	24	89.5	16
Орос хэл	14	10	4	71.4	2
Монгол хэл	507	460	47	90.7	35
<b>БҮГД</b>	<b>2739</b>	<b>2500</b>	<b>239</b>	<b>91.3</b>	<b>191</b>

Хичээлийн шинэ жилийн бэлтгэл хангах чиглэлээр: Цэцэрлэг, сургуулийн хүүхэд, эцэг эхчүүдэд халдвар хамгааллын дэглэм баримтлах, хүүхдийн аюулгүй байдлыг хангах, осол гэмтлээс урьдчилан сэргийлэх чиглэлээр "Хичээлийн шинэ жил эхэлж байна" нэртэй цахим контент боловсруулан олон нийтийн мэдээллийн хэрэгслээр сургууль, эцэг эхчүүдэд хүргээд байна. Боловсролын байгууллагын багш, ажилчид, сурагчдыг ковидын эсрэг вакцинд хамруулах ажлыг эрчимжүүлэх чиглэлийг сургууль, цэцэрлэгийн удирдлагуудад үүрэг болгож вакцинд хамрагдсан багш, ажилтан, сурагчдын нэгдсэн судалгааг гаргаж холбогдох байгууллагад хүргүүллээ.

Шинжилгээ болон дархлаажуулалтын зорилгоор 12 объект, тусгаарлах зорилгоор 19, эмнэлгийн зорилгоор 10, нийт 41 объектыг ашигласан бөгөөд үүнээс 22 сургалтын байранд ариутгал хийгдсэн.

Нийт 9 дотуур байрны зөөлөн эдлэлийг дайчлан ашиглалаа.

БШУЯ-аас 2021-2022 оны хичээлийн жилийн зорилго, зорилт болон бэлтгэл ажлыг хангах, сургалт, үйл ажиллагааны оролцогч талуудын үүрэг, оролцоо, цар тахлаас хамтдаа сэргийлэх боломж, цаашид анхаарах асуудлуудын талаар цахим сургалт зохион байгуулж, ЕБС-ийн захирал, сургалтын менежер, багш, нийт 700 гаруй албан хаагч хамрагдаж, мэдлэг чадвараа дээшлүүллээ.

Сургууль, цэцэрлэгийн хүүхдийг болзошгүй эрсдэлээс хамгаалах зорилгоор холбогдох албан хаагчдыг хариуцлагатай жижүүрээр хуваарийн дагуу ажиллуулж, сургалтын байгууллагын хэвийн үйл ажиллагааг алдагдуулахгүй байх, харуул хамгаалалтын ажилтны үүрэг хариуцлагыг өндөржүүлэх, хүүхдийг олон нийтийн газраар явуулахгүй байх, зах дэлгүүр лангуунд хүүхдээр худалдаа наймаа хийлгэхгүй байх талаар хяналт тавьж ажиллаж байна.

Цэцэрлэг, сургуулийн ариутгал, халдваргүйтгэл, хүүхдийн эрүүл аюулгүй сурч, хөгжих орчинд шаардлагатай материал, тоног төхөөрөмжийн судалгааг гаргаж санхүүгийн дэмжлэг үзүүлэх тухай хүсэлт салбарын яаманд уламжиллаа.

**Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн чиглэлээр:** "Шилжин суурьшигчдад тусалъя" төслийн хүрээнд нийгэм, сэтгэл зүйн зөвлөгөө үйлчилгээнд 21 хүнийг хамруулж, гэр бүлийн хүчирхийлэлд өртдөг 3 хүнийг илрүүлэн сэтгэл зүйн зөвлөгөө өглөө.

Есөнбулаг сумын иргэдийн гэр бүл, хүүхдийн эсрэг хүчирхийллээс урьдчилан сэргийлэх мэдлэг хандлагыг тодорхойлох асуулга судалгаанд Харзат багийн 40 иргэнийг хамруулж, хүүхэд хүмүүжлийн эерэг арга, гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх гарын авлагыг түгээж ажиллалаа.

Орон нутагт Ковид-19 цар тахлын нөхцөл байдал хүндэрч, халдварын тоо нэмэгдэж байгаатай холбогдуулан гэр бүлийн 2-оос дээш гишүүн халдвараар өвчилсөн 100 өрхөд, нийт 3500.0 мянган төгрөгийн дархлаа дэмжих багцыг олголоо.

"Гэр бүл зөвлөгөө өгөх төв"-өөр 15 хүн үйлчлүүлж, сэтгэл зүйн зөвлөгөө үйлчилгээнд хамрагдлаа. Гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг харьяа орон нутагтаа зохион байгуулах, хүчирхийллийн болзошгүй эрсдэлтэй гэр бүлийг илрүүлэх, мэдээлэх, хүчирхийллийг таслан зогсоох, үйлчилгээ үзүүлэх чиг үүрэг бүхий анхан шатанд ажиллаж буй 30 хамтарсан багийн үйл ажиллагаанд нийт 4500.0 мянган төгрөгийн дэмжлэг үзүүлэн, үйл ажиллагааг нь дэмжлээ.

Монгол Улсад залуучуудын хөдөлгөөн үүсэж хөгжсөний 100 жил, Залуучуудын хөгжлийн сарын аяны хүрээнд Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газраас 2021 оны 08 дугаар сарын 25-ны өдөр зохион байгуулсан Залуучуудын хөгжлийн үндэсний чуулганд аймгийн залуучуудын чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг клуб, зөвлөлийн төлөөлөл, нийт 100 залуу оролцож, санал бодлоо харилцан солилцлоо.

Залуучуудын хөгжлийн сарын аяны хүрээнд :

- "Хоггүй Алтайн төлөө" гүйе, түүе сайн дурын арга хэмжээ

- "Багадсан дүрэмт хувцасаа хандивлая" аян

- Гарааны бизнес эрхлэх сонирхолтой залуучуудад дэмжлэг үзүүлэх сургалт, нөлөөллийн үйл ажиллагаа зохион байгуулж, бүтээгдэхүүн үйл ажиллагааг олон нийтэд сурталчилах арга хэмжээ

- "Би хорт зуршилгүй залуу" нөлөөллийн ажлыг 15-21 насны өсвөр үеийн залуучуудад зохион байгуулж, холбон зуучлах, дэмжих бүлэг ажиллуулах арга хэмжээ

- Шинээр гэр бүл болж буй хосуудад гэр бүлийн боловсрол олгох "Аз жаргалтай гэр бүл" модуль сургалт

- Гэрлэх ёслолын үйл ажиллагаа зохион байгуулах арга хэмжээ

- Зорилтот бүлгийн өсвөр үе залуучуудад амьдрах ухааны 12 модуль сургалт зохион байгуулах

- Оюутан залуучууд, залуу ажилтан албан хаагчдаа бодлогоор дэмждэг, залуучуудад зориулсан хөтөлбөр, үйл ажиллагааг зохион байгуулдаг байгууллагуудын судалгааг гаргах, алдаршуулах

-“Эх орны хүү” сэдэвт эссэ бичлэгийн уралдаан болон сургалт нөлөөллийн арга хэмжээ зохион байгуулах

- Залуучуудын хөгжлийн зөвлөл байгуулах арга хэмжээг зохион байгуулах зэрэг болно.

Уралдаанд оролцох уралдаанч хүүхдийн бүртгэлийг аймгийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газарт зохион байгуулж, уралдааны үеэр Аймгийн Мэргэжлийн хяналтын газар, Цагдаагийн газар, Морин спорт уяачдын холбоо, даатгалын компаниудтай хамтран ажиллаж, уралдаанч хүүхдийн аюулгүй байдал, халдвар хамгаалалд хүүхэд хамгааллын баг хяналт тавьж ажиллалаа.

Элсэлтийн ерөнхий шалгалт эхлэхтэй холбогдуулан мэргэжил сонголтын талаар ганцаарчилсан зөвлөгөөг 8 хүүхдэд, бүлгийн зөвлөгөөг 12 хүүхдэд өгч ажиллалаа.

Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын Мазаалай театрт 46.5 сая төгрөгийн, 24 м<sup>2</sup> лед дэлгэц нийлүүлэх, угсрах, суурилуулах ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулж, гэрээ байгууллаа.

**Хөдөлмөр, халмажийн чиглэлээр:** Тус аймгийн 5 байгууллагын 12 орон тоонд ажилтан шалгаруулж авахаар захиалга ирүүлснийг цахимаар болон байгууллагын зарын самбарт байршуулан иргэдэд мэдээллээ.

Засгийн газрын 58 дугаар тогтоолоор баталсан “Залуучуудыг хөдөлмөрт бэлтгэх төсөл”-ийн хүрээнд хэрэгжүүлж буй “Оролцоо” төсөлд хамрагдах хүсэлтэй 18-34 насны 97 иргэнийг бүртгэж, 76 иргэнээс ярилцлага авч төсөлд хамруулахаар ажиллаж байна.

И-Халамж системд 08 дугаар сарын олголтыг үүсгэн иргэдийн данс руу хүүхдийн мөнгөн тэтгэмж 20959 хүүхдэд 2095.9 сая төгрөг, ихэр хүүхдийн тэтгэмж 1 иргэнд 2.0 сая, жирэмсэн эхийн тэтгэмж 507 иргэнд 17.5 сая, алдарт эхийн одон 28 иргэнд 2.8 сая, 0-3 хүртэлх насны хүүхдээ асарч буй эхэд олгох тэтгэмж 2812 иргэнд 137.2 сая, халамжийн тэтгэвэрт 1453 иргэнд 402.2 сая, онцгой тохиолдлын тэтгэмж 2 иргэнд 2.4 сая төгрөгийг тус тус илгээлээ. Ehalam системд бүртгүүлэхээр хүсэлт гаргасан шинэ төрсөн 97 хүүхдийн мэдээллийг баталгаажууллаа.

Мөн нийгмийн халамжийн нөхцөлт мөнгөн тэтгэмж 903 иргэнд 93.5 сая төгрөг, амьжиргааг дэмжих нөхцөлт мөнгөн тэтгэмж 185 иргэнд 49.2 сая, ахмадын хөнгөлөлт 1 иргэнд 0.1 сая, хөгжлийн бэрхшээлтэй иргэний хөнгөлөлт 57 иргэнд 2.1 сая, хүнсний эрхийн бичиг 667 өрхийн 3365 иргэнд 41.3 сая төгрөгийн санхүүжилтийг тус тус олголоо.

Нийгмийн даатгалын сангаас үйлчилгээ авагч иргэдийн тэтгэврийг 08 дугаар сарын 01-нд багтаан олгож, олгогдоогүй тэтгэвэр тэтгэмжийн өглөггүй ажиллалаа.

Хөдөлмөр нийгмийн хамгааллын яам, Нийгмийн даатгалын ерөнхий газраас өгсөн чиглэл болон Ковид-19 цар тахлын өвчлөлийн улмаас шалтгаалан хэлтсийн албан хаагч, сумдын байцаагч нарыг 08 дугаар сарын 02-ний өдрөөс эхлэн нэгдсэн журмаар ээлжийн амралт олгохоор зохицуулалт хийх шаардлагатай болсон тул ажлын байранд зайлшгүй үйлчилгээ үзүүлэх 3 албан хаагчийг ажиллуулж, бусад

албан хаагчид ээлжийн амралт олгосон. 08 дугаар сарын 23-аас амралт дууссан албан хаагчид ажилдаа орж ажиллаа.

**Нийгмийн даатгалын чиглэлээр:** Аймгийн хэмжээнд өндөр насны тэтгэвэр авагч 8970 хүнд 33824.5 сая төгрөгийг олголоо. Шинээр тэтгэвэр тогтоолгохоор хүсэлт гаргасан өндөр настан 15, тахир дутуу 3, тэжээгчээ алдсаны тэтгэвэр 2, нийт-20 даатгуулагчийн тэтгэврийн баримт материалыг хүлээн авч хуулийн хүрээнд шийдвэрлэлээ.

Тэтгэмжийн даатгалын сангаас жирэмсэн амаржсаны тэтгэмж 29 хүнд 53.3 сая, хөдөлмөрийн чадвар түр алдсаны тэтгэмж 16 хүнд 2.5 сая, оршуулгын тэтгэмж 8 хүнд 8.0 сая, ажилгүйдлийн тэтгэмж 21 хүнд 12.8 сая төгрөгийг тус тус олголоо.

Сайн дурын даатгалд нийт 32 хүн хамрагдсанаас 22 хүн ажилгүй, 0-3 насны хүүхдээ асарч буй 10 эхийг хамрууллаа.

Эрүүл мэндийн даатгалд 963 иргэн хамруулж 58.6 сая төгрөг ЭМД-ын санд хуримтлагдлаа.

Эмнэлэг хөдөлмөрийн магадлах комиссын хурлаар 85 хүн орж, үүнээс шинээр-12 хүн хөдөлмөрийн чадвар алдалт тогтоолгож, 71 хүний групп сунгагдлаа. Цуцлагдсан 2 хүн байна.

Нийгмийн даатгалын шимтгэл төлөлттэй холбоотой лавлагааг 24 хүнд гаргаж өглөө.

## ДОЛОО. БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ЧИГЛЭЛЭЭР

Улсын чанартай авто зам, аялал жуулчлалын гол бүс Цогт сумын Ээж хайрхан, Дэлгэр, Тайшир, Есөнбулаг сумдын зам дагуу 5 ширхэг хогийн пункерийг байгаль хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний 25.0 сая төгрөгөөр хийж гүйцэтгэлээ.

Сутай хайрхан уулын тахилгын арга хэмжээнд орчны бохирдлын талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээний удирдамж төлөвлөгөө боловсруулан, уг арга хэмжээний үеэр Байгаль орчны тухай хууль, Хог хаягдлын тухай хууль, Амьтны тухай хуулиудаар гарын авлага тараах материалуудыг ард иргэдэд сурталчилан ажиллалаа.

Аймгийн хэмжээнд 18 сум, 2 ААНБ-ын аюултай хог хаягдал үүсгэгчийн мэдээллийг БОАЖЯ-ны цахим мэдээллийн санд байршууллаа.

**Хяналт шалгалтын чиглэлээр:** “Болд гянт болд” ХХК-аас ирүүлсэн хүсэлтийн дагуу Зүүн сайрын алтны шороон ордын уурхайн нөхцөл байдал, 2021 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтэд явцын хяналт шалгалт хийн, зөвлөмж хүргүүлэн, хэрэгжилтийг тооцон ажиллаж байна.

Улсын хэмжээнд зохион байгуулагдаж буй нөхөн сэргээлт 2024 арга хэмжээний хүрээнд энэ онд 4 сумын 50.77 га талбайд нөхөн сэргээлтийн ажлыг хийхээр төлөвлөж, холбогдох аж ахуй нэгж байгууллага болон сумдын удирдлагуудад 9 дүгээр сарын 15-ны дотор нөхөн сэргээлтийн ажлыг стандартын дагуу хийлгэн, хүлээн авах арга хэмжээг зохион байгуулж ажиллах үүрэг чиглэлийг хүргүүллээ.

Мөн тус арга хэмжээний хүрээнд □Есөнбулаг сумын Рашаант багийн нутагт хууль бусаар ашигт малтмал олборлогчдын үйл ажиллагааны улмаас эвдрэлд орж орхигдсон 3 газарт “Алтай бичил уурхайчдын эв нэгдлийн холбоо”-ны бичил уурхайчид нийгмийн хариуцлагын хүрээнд нийт 3,54 га талбайд техникийн нөхөн сэргээлтийн ажлыг хийж гүйцэтгэснийг хүлээн авлаа.

**Аялал жуулчлалын чиглэлээр:** Монгол Улс дахь НҮБ-ын хөтөлбөрийн хүрээнд нутгийн иргэд, малчдад аялал жуулчлалын салбарын оролцоог нэмэгдүүлэхэд чиглэсэн “Гэр ба байгаль ” (GN) схемийг боловсруулах судалгааны ажлыг манай аймагт эхлүүлээд байна.

Тус аймагт аялал жуулчлалыг хөгжүүлэх цогц бодлогын баримт бичиг боловсруулах ажлыг шууд гэрээ байгуулах эрх олгогдсон аймгийн Засаг даргын 2021 оны 07/20-ны А/325 тоот захирамжийн дагуу ОАСИС БЕАР ХХК-тай гэрээ байгуулан ажлыг эхлүүлээ.

Баримт бичиг боловсруулах ажлын хүрээнд гүйцэтгэгч компанитай хамтран хээрийн судалгааны ажлыг Бигэр, Цогт, Цээл, Эрдэнэ, Бугат, Тонхил, Төгрөг, Шарга сумдад гүйцэтгэж аялал жуулчлалын маршрутад оруулах түүх дурсгалын үнэт өв, соёлын талаарх судалгааны ажлыг хийлээ.

#### НАЙМ.СУМДАД ЗОХИОН БАЙГУУЛСАН ОНЦЛОГ АЖЛЫН ТАЛААР

**Баян-Уул сум:** Байгаль орчин, аялал жуулчлалын яамтай байгуулсан 202101 тоот гэрээ, 2021 оны 08 дугаар сарын 04-ний өдрийн 03/3441 тоот зөвшөөрлийн дагуу Арабын Нэгдсэн Эмират Улсын Дубай хотын захирагчийн бие төлөөлөгч болон түүний орчуулагч нартай гэрээ байгуулан, идлэг шонхор шувуу барих үйл ажиллагаанд хяналт тавин ажиллаж байна.

**Шарга сум:** Тус сум 8 сарын 13, 14-ний өдрүүдэд Үндэсний өв соёлын өдрийг тэмдэглэн, 6 насны морьдын уралдаан, 64 бөхийн барилдаан, залуу бөхийн тойргийн барилдаан, Үндэсний сурын харваа, Ганган хос шалгаруулах уралдаан, Морь, бөх цоллоочдын уралдааныг тус тус зохион байгууллаа.

**Эрдэнэ сум:** Сумын түүх болон үзэсгэлэнт газар, түүх соёлын дурсгалыг харуулсан баримтат киноны зураг авалтын урьдчилсан хөтөлбөрийг гаргаж, хөтөлбөрийн дагуу киноны зураг авалт хийгдсэн.

ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР

